

АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛНИЙН ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 04-нд

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагаа	Биелэлт	Зарцуулсан төсөв
1.	Хуралдаан	<p>Огноо:</p> <ul style="list-style-type: none">✓ 2022 оны 01 дүгээр сарын 04-нд 1 дүгээр хурал✓ 2022 оны 03 дугаар сарын 14-нд 2 дугаар хурал✓ 2022 оны 06 дугаар сарын 07-нд 3 дугаар хурал✓ 2022 оны 08 дугаар сарын 18-нд 4 дүгээр хурал✓ 2022 оны 10 дугаар сарын 06-нд 5 дугаар хурал✓ 2022 оны 11 дүгээр сарын 15-нд 6 дугаар хурал <p>Хэлэлцсэн баталсан:</p> <p>1 дүгээр хурал:</p> <ul style="list-style-type: none">✓ 2022 оны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Нийт 8 ажил хийхээр төлөвлөгдөж 2022 оны эхний 11 сарын байдлаар хэрэгжилт 98 хувьтай байна.✓ Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн шалгалтанд оролцох эмч, эх баригч, сувиллагчийн материалыг хүлээн авч эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн зөвшөөрлийг хэлэлцэхээр Ёс зүйн хэсгийн хороо хуралдаж<ul style="list-style-type: none">▪ “Ахлах” зэрэгт орох-3▪ “Тэргүүлэх” зэрэгт орох-7▪ “Зөвлөх” зэрэгт-2▪ Мөн зэргээ хамгаалах тайлан хамгаалалтанд орох нийт 17 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тодорхойлолт гаргаж өгсөн. <p>2 дугаар хурлаар:</p> <ul style="list-style-type: none">✓ Дэлхийн эмч нарын баярын өдрийг тохиолдуулан Монголын Эрүүл мэндийн ажилтны ҮЭХ-оос 10 дахь жилдээ зохион байгуулагдаж буй “АЛТАН ЧАГНУУР-2022” шилдэг эмч шалгаруулах ёслолын арга хэмжээний “ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СУДЛАЛ” төрөлд “АЛТАН ЧАГНУУР”-ын эзэнээр Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Амбулаторийн тасгийн	

эрхлэгч, Эх барих эмэгтэйчүүдийн "Зөвлөх" зэрэгтэй эмч, Клиникийн профессор, Ёс зүйн хэсгийн хорооны дарга Л.Долгоржав шалгарсан.

3 дугаар хурлаар:

✓ ААГТМЭ-ийн захирлын зөвлөлийн 2022.06.06-ны өдрийн №20 дугаар хурлаас гарсан шийдвэрийг танилцуулсан.

4 дүгээр хурлаар:

✓ Эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд ЭМС-ын тушаалыг эргэн сануулах, сургалт зохион байгуулах

5 дугаар хурлаар:

✓ Ёс зүйн хэсгийн хорооны даргын мэдээлэл 09 дүгээр сарын санал хүсэлтээс нэр дурдаж орж ирсэн эмч, эмнэлгийн ажилтныг авч хэлэлцэх

✓ 8 сард орж ирсэн эмч, эмнэлгийн ажилтны хооронд үүссэн ёс зүйн гомдол хэлэлцэх

✓ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт, хийгдэх үйл ажиллагааны төлөвлөлтийг гаргах, эрчимжүүлэх

6 дугаар хурлаар:

✓ 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргах, хариуцсан ажлуудыг эрчимжүүлэх тухайн онд бүрэн хэрэгжүүлэх, тайланг нэгтгэн гаргаж ЭМЯ-аас ирсэн 2022.10.31-ний 22/95 албан тоотын хариуг хугацаанд хүргүүлэх.

Шийдвэр:

1 дүгээр хурал:

✓ Төлөвлөгөөг 8 ажил хийгдэхээр баталсан. Хариуцан гишүүдийг тодорхой болгосон.

✓ Зэрэг горилж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хэлэлцэн дэмжин тодорхойлсон.

2 дугаар хурал:

✓ Эх барих эмэгтэйчүүд судлал төрөлд Амбулаторийн тасгийн эрхлэгч ЭБЭ-ийн эмч Л.Долгоржавыг дэмжиж материалыг хүргүүлсэн.

3 дугаар хурал:

✓ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны орлогч дарга Нярайн тасгийн Нярайн эмч Р.Намуунсүрэн нь байгууллагын цахим хуудсаар дамжуулан Ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр цахим сургалтыг үе шаттай цахим хуудсанд байршуулан эмч, эмнэлгийн ажилтнуудыг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.

4 дүгээр хурал:

	<p>✓ ЭМС-ын 2019 оны 406 тоот тушаалыг танилцуулан нийт эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд төстээр шалгалт авч нэгтгэл дүнд тулгуурлан сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиглаж нийт эмч, эмнэлгийн ажилтнуудыг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлсэн.</p> <p>5 дугаар хурал:</p> <p>✓ Хэлэлцэн шийдвэрлэж эмч, эмнэлгийн ажилтнуудын дунд соён гэгээрүүлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, аян өрнүүлж хэрэгжилтийг танилцуулах.</p> <p>6 дугаар хурал:</p> <p>✓ 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн, тайланг нэгтгэн гаргаж ЭМЯ-аас ирсэн 2022.12.05-нд гарган хүргүүлэх.</p>			
<p>2. Сургалтад хамрагдсан хүний тоо</p>	<p>Эмч 245</p>	<p>Эмнэлгийн мэргэжилтэн 494</p>	<p>Эмнэлгийн бусад ажилтан 128</p>	<p>Иргэд үйлчлүүлэгч -</p>
<p>3. Ёс зүйн сургалтын сэдэв</p>	<p>2022 онд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг дээшлүүлэх зорилгоор дараах үйл ажиллагаа, сургалтуудыг хийсэн. Үнд:</p> <ul style="list-style-type: none"> • ЭМЯ-ны Ёс зүйн салбар хорооноос цахимаар зохион байгуулагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, “Ковидын үеийн эмнэлгийн мэргэжилтний сэтгэл зүй” сургалтанд давхардсан тоогоор 345 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд үзэж танилцсан. • Ёс зүйн салбар хорооноос ЭМС-ын “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” А/406 дугаар тушаалын танилцуулгыг бэлтгэн, байгууллагын цахим хуудсанд байршуулсан ба 195 эмч, эмнэлгийн мэргэжилтэн уншиж танилцсан ба шинээр ажигд орж буй эмч, ажилтнуудад тушаалыг уншуулж, ярилцлага хийж хэвшсэн. • 2022 онд эмч, эх баригч, бусад ажилтнуудын дунд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн мэдлэг үнэлэх сорилыг 20 асуултаар 100%-ийн үнэлэхээр нийт эмч, эмнэлгийн ажилтны 210 буюу 81.4%-ын хамруулсан. Шалгалтыг дүгнэхэд нийт ажилтны 70%-иас дээш хувийн хангалттай үнэлгээ авсан 83% буюу 175 ажилтан, хангалтгүй үнэлэгдсэн 17% буюу 35 ажилтанд холбогдох хууль, эрх зүйн бичиг баримтыг судлах, эргэн танилцуулах, давтан төстийн шалгалтанд хамруулах үүрэг даалгаврын өгч ажигласан. • Хүний нөөцийн менежер Б.Саранцэцэг нь Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн шинэчлэгдсэн дүрэм бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйл “Ажлын байрны дарамт хүчирхийлэл хуулийн заалтыг танилцуулах гэх.мэт 3 удаагийн танхимын сургалтыг хийж 			

	<p>давхардсан тоогоор 260 эмч, эмнэлгийн ажилтанд танилцуулсан. Мөн ДАГТМЭ-ийн 2022 оны Захирлын А/19 тоот тушаал “Ажлын байрны дарамт хүчирхийлэл” журмыг танилцуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрчний эвлэл, Ёс зүйн хэсгийн хороо хамтран Би Трендс бүсгүй, Migale Me номуудын зохиолч, олон улсын эрхтэй көүч Т.Гүлдаурен зохиолчын Хувь хүний хөгжил, менежментийн чиглэлийн 20 видео хичээл сургалтыг 2021 оноос эхлэн нийт ажилтнууддаа онлайн цахим хэлбэрээр танилцуулж ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарч ажилсан. • Мөн байгууллагын зүгээс zangia.mn-нд гишүүн байгууллагаар хамрагдаж төрөл бүрийн хичээл гарын авлага, танин мэдэхүйн чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын бус цагаар төлөвшүүлэх олон төрлийн сургалтанд онлайн хэлбэрээр хамрагдах эрхийг нээж өгсөн. • Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны орлогч дарга Нарайн тасгийн Нарайн эмч Р.Намуунсүрэн нь байгууллагын цахим хуудсаар дамжуулан Ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр цахим сургалтыг үе шаттай цахим хуудсанд байршуулан эмч, эмнэлгийн ажилтнуудыг соён гэгээрүүлэх ажлыг хийж байна. Үндэ : <ul style="list-style-type: none"> ○ ЭМС-ын 2019 оны А/406 дугаар тушаал ○ Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байранд мөрдөх нийтлэг журам, ○ Ёс зүйн үндсэн 5 зарчмыг эргэн саная. ○ Ёс зүй, хууль эрх зүйн чиглэлээр дээд шатны байгууллагаас гаргасан мэдээ, мэдээлэл ○ ЗГ-ын 33 дугаар тогтоолын хавсралт “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” ○ Ёс зүйн хэсгийн хорооноос “Энгэрийн тэмдгээ зүүж хэвшцгээе” уриатай зурагт боршуурыг Амгалан амаржих газар ажиллагсад фэйсбүүк гүрл-д байршуулсан • Ёс зүй, хууль эрх зүйн чиглэлээр дээд шатны байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг тухай бүр цахим хуудас, болон мэдээллийн самбарт байршуулан ажилласан. • ЗГ-ын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” 	<p>НЭ-ийн хороотой хамтран/</p>
--	---	---------------------------------



Т.Гүлдаурен
 Сүүлийн үндсэн буюу ХИЧЭЭЛ НЭЭЭ
 ТООДУУ МАТТЕРС
 Хамгийн чухал цаг хугацаа бол ӨНГӨРСӨН БИШ ИРЭЭЛЭЙ БИШ
 ХЭРИН ӨНӨӨДӨР ЮМ. ӨНӨӨДӨӨР АМЬСЭЭВЭЙН ТААВАР ХАГИЙН
 ЧУХАЛ ҮЙЛЧИЙГ ТААХН БОЛГОНО УУ
 Миний 20 ичээлээр хамт байсан 19 бүхэндээ маш их саярлалаа

	<p>Үр дүн: 2022 онд эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлын байрны ба цахим сургалтуудыг давхардсан тоогоор 12 удаа нийт 867 удаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд үзэж танилцсан байна.</p>																					
<p>4. Хүлээн авах</p>	<table border="1"> <tr> <td data-bbox="1147 453 1224 995">Иргэн</td> <td data-bbox="1147 995 1224 1327">Эмнэлгийн мэргэжилтэн</td> <td data-bbox="1147 1327 1224 1570">Хэсгийн хороо, /ёс зүйн баг /</td> <td data-bbox="1147 1570 1224 1869">Хяналтын хорооноос шилжүүлсэн</td> </tr> <tr> <td data-bbox="1108 453 1147 995">○ Эвлэрүүлэн зуучилсан</td> <td data-bbox="1108 995 1147 1327">-</td> <td data-bbox="1108 1327 1147 1570">-</td> <td data-bbox="1108 1570 1147 1869">-</td> </tr> <tr> <td data-bbox="1070 453 1108 995">○ Хөдөлмөрийн хуулийн дагуу</td> <td data-bbox="1070 995 1108 1327">-</td> <td data-bbox="1070 1327 1108 1570">-</td> <td data-bbox="1070 1570 1108 1869">-</td> </tr> <tr> <td data-bbox="1031 453 1070 995">○ Эмчлэх эрхийн зөвшөөрөл</td> <td data-bbox="1031 995 1070 1327">-</td> <td data-bbox="1031 1327 1070 1570">-</td> <td data-bbox="1031 1570 1070 1869">-</td> </tr> <tr> <td data-bbox="993 453 1031 995">○ Зөрчлийн бүртгэсэн</td> <td data-bbox="993 995 1031 1327">-</td> <td data-bbox="993 1327 1031 1570">-</td> <td data-bbox="993 1570 1031 1869">-</td> </tr> </table>	Иргэн	Эмнэлгийн мэргэжилтэн	Хэсгийн хороо, /ёс зүйн баг /	Хяналтын хорооноос шилжүүлсэн	○ Эвлэрүүлэн зуучилсан	-	-	-	○ Хөдөлмөрийн хуулийн дагуу	-	-	-	○ Эмчлэх эрхийн зөвшөөрөл	-	-	-	○ Зөрчлийн бүртгэсэн	-	-	-	
Иргэн	Эмнэлгийн мэргэжилтэн	Хэсгийн хороо, /ёс зүйн баг /	Хяналтын хорооноос шилжүүлсэн																			
○ Эвлэрүүлэн зуучилсан	-	-	-																			
○ Хөдөлмөрийн хуулийн дагуу	-	-	-																			
○ Эмчлэх эрхийн зөвшөөрөл	-	-	-																			
○ Зөрчлийн бүртгэсэн	-	-	-																			
<p>5. Эвлэрүүлэн зуучилсан тохиолдлын тоо</p>	<table border="1"> <tr> <td data-bbox="831 453 947 995">Эмч, үйлчлүүлэгчийн хооронд</td> <td data-bbox="831 995 947 1327">Эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч хооронд</td> <td data-bbox="831 1327 947 1570">Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хооронд</td> <td data-bbox="831 1570 947 1869">Эмч, эмнэлгийн мэргэжилтэн удирдлагын хооронд</td> </tr> <tr> <td data-bbox="793 453 831 995">-</td> <td data-bbox="793 995 831 1327">-</td> <td data-bbox="793 1327 831 1570">1</td> <td data-bbox="793 1570 831 1869">-</td> </tr> </table>	Эмч, үйлчлүүлэгчийн хооронд	Эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн удирдлагын хооронд	-	-	1	-													
Эмч, үйлчлүүлэгчийн хооронд	Эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн удирдлагын хооронд																			
-	-	1	-																			
<p>6. Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх чиглэлээр хийсэн ажил /Ажлын хураангуй, хүрсэн үр дүн/</p>	<ul style="list-style-type: none"> • Ёс зүйн хэсгийн хорооноос 2022 оны 10 дугаар сард “Ажлын байранд стандарт хувцаслагтыг мөрдүүлэх” аяны зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд ажлын байранд мөрдөх нийтлэг журмыг хэвшүүлж мөрдүүлэх /ЭМС-ын 2015 оны 189 тушаал/-ын дагуу 9 алба, 8 тасгийн эмч, эмнэлгийн ажилчдын 80 дээш хувийг хамруулж, Ёс зүйн хэсгийн хорооны гишүүд батлуулсан хуваарийн дагуу 7 асуумж бүхий үнэлгээний хуудсаар 2022.06.15-30-ны өдөр хүртэл 10 хоног, 2022.10.05-14-ний өдөр хүртэл 10 хоногийн хугацаанд 2 удаа хөндлөнгийн үнэлгээ хийсэн. Нийт 248 эмч, эмнэлгийн ажилтан ажилладаг. Үүнээс 72 эмчээс хамрагдсан 58 буюу 80%, 110 сувиллагч тусгай мэргэжилтнээс 88 буюу 80%, 66 бусад ажилтнаас 52 буюу 85% нь тус тус хамрагдсан. Үнэлгээнд нийт 198 эмч, эмнэлгийн ажилчид буюу 80% нь хамрагдсан байна. <ul style="list-style-type: none"> ○ Асуумж тус бүрээр авч үзвэл: <ul style="list-style-type: none"> ○ Харилцаа үүсгэж, мөндөлгөн эсэх- 183 ажилтан 92% ○ Байгууллагын дотоод журмын дагуу стандартаар хувцасласан эсэх-159 ажилтан 80% ○ Энгэрийн тэмдэг зүүсэн эсэх- 187 ажилтан 94% ○ Үсээ стандартын дагуу боож, бантик зүүсэн эсэх / Тод анхаарал татсан өнгөөр будахгүй байх/ - 180 ажилтан 91% ○ Ажилбарын үед цаг, булгүйвч, бөлж зүүсэн эсэх- 190 ажилтан 96% 	<p>ДАГТМЭ-ийн Захиргаа, Ёс зүйн хэсгийн хороо</p>																				

- Ажлын байранд гарын хумс хиргүй, цэвэрхэн, богино засалттай, будаггүй байх-175 ажилтан 88%
 - Ажлын байранд заасан стандартын дагуу эзэмг зүүлт зүүсэн эсэх- 194 ажилтан 98%-тай үнэлэгдсэн.
 - Тайлбар:
 - Харилцаа үүсгэж, мэндэлсэн эсэх- 183 ажилтан 92%, /15 ажилтан буюу 8 хувь нь харилцаа үүсгээгүй, мэндлээгүй/
 - Байгууллагын дотоод журмын дагуу стандартаар хувиасласан эсэх-159 ажилтан буюу 80%, /39 ажилтан буюу 20 хувь нь стандартын хувиасаа өмсөөгүй байсан. Шалтгаан нь хувиасаа алдсан, өнгө нь цайрсан, хуучирсан, таарахгүй болсон байна./
 - Энгэрийн тэмдэг зүүсэн эсэх- 187 ажилтан 94%, /11 ажилтан буюу 6 хувь нь энгэрийн тэмдгийг тогтмол зүүхгүй байна/
 - Үсээ стандартын дагуу боож, бантик зүүсэн эсэх /Тод анхаарал татсан өнгөөр будахгүй байх- 180 ажилтан 91%, /18 ажилтан буюу 9 хувь нь үсээ боохгүй, задгай, тод өнгөөр будсан/
 - Ажилбарын үед цаг, бүлгүүвч, бөгж зүүсэн эсэх- 190 ажилтан 96%, /8 ажилтан буюу 4 хувь нь бөгж, цаг зүүсэн/
 - Ажлын байранд гарын хумс хиргүй, цэвэрхэн, богино засалттай, будаггүй байх-175 ажилтан 88% /23 ажилтан буюу 12 хувь нь урт хумстай, тод өнгийн будагтай байна/
 - Ажлын байранд заасан стандартын дагуу эзэмг зүүлт зүүсэн эсэх- 194 ажилтан 98%, /5 ажилтан буюу 2 хувь байна/
- Эмчилгээ үйлчилгээний 9 тасаг нэгж бүр өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тасаг бүрт мини номын санг байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтний чөлөөт цагийг зөв, боловсон өнгөрүүлэх тал дээр шинийг санаачлан ажиглаж байна.
 - ID card хэвлэгч, Evois рiптасу принтерийг өөрсдийн худалдан авалтаар авч Нийт эмч, эмнэлгийн ажилчдын ажлын үнэмлэх,




цагийн бүртгэл, хаалганы чил гэх 3 үйлдлээр нэгтгэн цогц үйлчилгээ болгон ашиглах ажил хийгдэж байна.

- 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Цахим хөгжлийн багц хууль буюу "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" "Цахим гарын үсгийн тухай" "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" "Кибер аюулгүй байдлын тухай" товч танилцуулга хийж мэдээлэл өгсөн.



- ЗГ-ын 2019 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 139 дүгээр тогтоолын дагуу "Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах 2022-2026 он арга хэмжээ"-г 9 бүлэг 7 зорилтын хүрээнд боловсруулж эмнэлгийн захирлаар батлуулж, 2022 оны хэрэгжилтийг 100 хувь ханган ажигласан.

- Нийслэлийн цагдаагийн удирдах газраас 2022.11.29-нд "НАНДИН БҮХНЭЭ ХАМИГАЛТЪЯ" аяны хүрээнд "Гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх үүрэг" сэдвээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулсан.



- Сэтгэл гутрал, түгшил, нойргүйдлийн эмийн бус эмчилгээ Alpha Stim SCS нь хатуу физик электроникийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий аппаратаар амаржих газрын ээлжийн ажилтай сувилалч, эх баригч нарыг ажгаас буусан үед эмчилгээнд хамруулахаар тусгай өрөө гарган тохижуулж ажилчдыг эмчилгээнд хамруулж нийт-16 сувилалч тусгай мэргэжилтнүүд хамрагдсан байна.

Үр дүн: Эмч, эмнэлгийн мэргэжилтний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлын байрны болон цахим сургалтуудыг тасралтгүй зохион байгуулахын зэрэгцээ мэдлэг олгох, соён гэгээрүүлэх талаар шинэ ном товхимол, гарын авлагаар байгууллагын номын санг баяжуулан, үйл ажиллагааг өргөжүүлэн давхардсан тоогоор нийт 630 удаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд үзэж танилцсан байна.



<p>7.</p> <p>Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил /Ажлын хураангуй, хүрсэн үр дүн/</p>	<p>“Төрөлтийн тусламжийг дэмжигч” Олон Улсын эвслийн (International Childbirth Initiative) “Эх Хүүхэд Гэр бүлд ээлтэй эмнэлэг”-ийн 12 алхамт (12 Steps to Safe and Respectful MotherBaby-Family Maternity Care) төслийг АШУУИС, Япон улсын “Цукуба” их сургуультай хамтран хэрэгжүүлж 12 алхмын анхан шатны шалгаруулалтыг 2021.07.28-ны өдөр амжилттай нэвтрүүлж, гэрчилгээ гардан авсан. Цаашид алхам бүрийг үе шаттай тасралтгүй нэвтрүүлж, эх хүүхдэд ээлтэй эмнэлэг болох зорилго тавин ажиглаж байгаа ба 2022.10.17-18-ны өдрүүдэд Япон улсын Цукуба их сургуулийн доктор, профессор Асако Т.К, доктор, ассистент профессор Т.Ганчимэг болон АШУУИС-ийн Сувилгахуйн сургуулийн багш нартай хамтран “Эх хүүхэд-Гэр бүлд ээлтэй, хүндэтгэлтэй эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлэх 12 алхам”-ын чиглүүлэх сургалтыг 50 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгууллаа.</p> <p>2019 онд Доула буюу Төрөлтийн хамтрагч төслийг анх удаа амаржих газарт АШУУИС, Япон улсын Цукуба их сургуультай хамтран амжилттай хэрэгжүүлж, төрөх тасагт ээлжийн төрөлтийн хамтрагчийг ажиглуулж эхэлсэн ба цаашид Доулаг үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй байлгах зорилгоор 12 эх баригч, туслах сувилалчийг сургалтад хамруулж, гэрчилгээг гардууллаа.</p> <p>Нийгмийн асуудал шийдвэрлэлтийн хүрээнд: Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг дэмжих сарын хүрээнд эмч, эмнэлгийн ажилтнуудад бодит дэмжлэг үзүүлсэн. 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт ажилтанд 8 удаагийн урамшуулал олгосон ба 08 сард Удирдлагын зөвлөлийн 2022.08.10-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрээр Ерөнхий захирлын 2022.08.10-ны өдрийн “Орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг олгох тухай” Б/117 тоот тушаалаар нийт 7 ажилтанд нийт 85 сая.төгрөг үнд байрны урьдчилгаа 2 ажилтанд нийт 60 сая.төг, эмнэлгийн хэмжээнд өрх толгойлсон, амьдарлыг түвшин доогуур бага орлоготой, олон хүүхэдтэй, түрээсийн гэрт амьдардаг 5 ариутгагч, туслах сувилал, үйлчилгээний ажилтанд иж бүрэн таван ханатай гэр олгосон нийт 25 сая.төг зарцуулсан.</p>	 
--	---	--


Тус эмнэлгээс 2022 оны 08 сард "Ахмадын дэмжих сар"-ыг тохиолдуулан өндөр настны тэтгэвэрт гарсан нийт 75 эмч, эмнэлгийн ажилтанд "Дархлаа дэмжих багц" 5 нэр төрлийн бүтээгдэхүүн, Эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдах "Урилга" ерөнхий захирлын талархлын хуудсын хамт хүргүүлсэн.

Эмч, эмнэлгийн ажиллагсдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, бүтээлч санаачилга, сонирхол хобби нь дэмжих зорилгоор "Гар урлал-Миний хобби" сэдэвт уралдааныг 2022 оны 10 сард зохион байгууллаа. Уралдаанд нийт 9 бүтээл оролцсоноос Тэргүүн байрыг Төрөх, төрсний дараах тасгийн эх баригч Б.Тунгалагтуяа, Дэд байрыг Төлөвлөгт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Н.Мөнхцэцэг, Гурав дугаар байрыг лаборант Б.Үүрийнтуяа, Тусгай байрыг даатгалын бага эмч Э.Нямдолгор, эх барих эмэгтэйчүүдийн эмч Б.Түвшин-Эрдэнэ, туслах сувилалч Б.Пүрэвдулам нар шалгарсан. 2-р шатанд 2022.10.28-нд МУЭ-ийн Соёлын төв өргөөнд 50 гаруй төрөл бүтээлүүдээр анхан шатны ҮЭ-ийн хороодын гишүүн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтнууд өрсөлдөж Амаржих газрын Төрөх, төрсний дараах тасгийн эх баригч Б.Тунгалагтуяа тусгай байр эзэлсэн.

2022 онд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих" жилийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулагдсан дэд бүтэц, орчны хүртээмжийг сайжруулах чиглэлээр 5 ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг утган Ковид-19 халдавч авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэцдэд зориулсан 1 сарын хугацаанд дохионы хэлмэрч, орчуулагч Б.Мядагтай хамтран ажиллаж Эрүүл мэндийн боловсрол олгох цахим сургалтыг хамтран зохион байгуулж байна.

"Жендерийн Үндэсний Хороо"-оос Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилготой ОУ-ын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах өдөр, Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан Үндэсний хэмжээнд "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ" аянд 2022 онд эмнэлгийн хамт олон нэгдэж ажилласан.



	<p>ЭМХТ, ЦЕГ-ын хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтад нийт 81 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдав.</p> <p>Байгууллагын цахим хуудаснаа өсвөр үе залууст зориулан халдварт болон халдварт бүс өвчнөөс сэргийлэх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох мэдээ мэдээлэл 56, видео контент 20 байршуулсан.</p> <p>Нийслэлийн Ерөнхий боловсролын 132 дугаар сургуулийн бага ангийн 1А, 1Б, 2А, 2Б ангиудад, мөн Нийслэлийн Ерөнхий боловсролын 69 дүгээр сургуулийн 1Ж ангийн сурагч нарт “Гар угаах дараалал”, “Амны хөндийн эрүүл мэнд, Шүдээ хэрхэн зөв угаах талаар”, “Томуу, томуу төст өвчин”, “Гар угаах дараалал” гэсэн сэдвүүдээр нийт 142 сурагчдад сургалтыг явууллаа.</p> <p>Шилжилтийн эгзэгтэй насан дээрээ яваа өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг ерөнхий боловсролын 33-р сургуулийн 5А ангийн сурагч нарт болон Хошими нэрэмжит 14-р лаборатори сургуулийн 12Е, 10Е, 10В, 10Г ангиудад “Шилжилтийн насанд гарах өөрчлөлт”, “Бэлгийн замын халдварт өвчин”, “Гэр бүл төлөвлөлт”, “Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл” гэсэн сэдвүүдээр 165 хөвгүүд, охидод тус тусад нь сургалтыг зохион байгуулснаар тэдэнд өөрсдийн насны онцлог, сэтгэл зүйн тулгамдсан асуудал, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг, арга зүйг эзэмшүүлсэн.</p> <p>Ур дүн: Эмнэлэг нь нийгмийн хариуцлагынхаа хүрээнд тусгай хэрэгцээт болон зорилгот бүлгийн нөхөн үржихүйн насны охидод эрүүл мэндийн боловсрол олгохоор зохион байгуулсан үйл ажиллагаа маань зөв хандлага төлөвшүүлэхэд үр дүнтэй шинэлэг ажлууд болсон.</p>	
<p>8. Цахим хуудасны мэдээллийг баяжуулсан байдал</p>	<ul style="list-style-type: none"> Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн санал гомдлыг Чанарын алба хүлээн авч судлан шийдвэрлэлтийн явц, хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэнд хариуг утсаар, цахимаар, биечлэн хүртэж үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлж, харилцаагаа зөргээр төгсгөн эргэх холбоотой ажилласнаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцаа хандлага төлөвшиж, санал гомдлын тоо бууруулан ажиглаж байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, авилга ашиг сонирхолтой холбоотой санал, хүсэлт, гомдлыг ажлын өдрүүдэд /08.20-16.20/ цагийн хооронд Дотоод хяналтын ажилтан, Чанарын алба хүлээн авч судлан шийдвэрлэлтийн явц, хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэнд хариуг утсаар, цахимаар, биечлэн хүртэж үйлчлүүлэгчийн хэрэгцээг тодорхойлж, харилцаагаа зөргээр төгсгөн эргэх холбоотой ажилласнаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцаа хандлага төлөвшиж, санал гомдлын тоо буурсан. <p>www.amgalaan.moh.gov.mn Мэдээллийн санг үйлчлүүлэгчид хэрэгтэй мэдээ мэдээлэлээ хурдан шуурхай олоход хялбар болгож өгсөн: Үндсэн сайт, Байгууллагын мэдээллийн сан гэж 2 ангилсан.</p>	

Үүнд: Эмнэлгийн тусламж үйлчилгээ, статистик мэдээ, сонгон шалгаруулалт, нээлттэй ажлын байрны мэдээ зэргийг илүү хялбарчилж өгсөн.

2022 оны 11 сарын байдлаар цахим хуудсанд мэдээ, мэдээлэл-87, зөвлөгөө-65, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулж видео зөвлөмж-5, үйлчлүүлэгчид зориулсан зөвлөмж-30 тус тус байршуулсан.

Үүнд:

- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Захирлын тушаал- 13
- Санхүүгийн мэдээ- 1-11 сар
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны мэдээлэл- 8
- Статистик мэдээ, үндсэн үзүүлэлт -1-11 сар
- Нээлттэй ажлын байрны зарыг 17 удаагийн давтамжтай-28
- Зөвлөгөө зөвлөмж –244
- Мэдээ, мэдээлэл – 87 тус тус оруулсан.

Цахим хуудасны цэсүүд:

Хууль эрх зүй:

Дээд газраас ирсэн захирамжталын баримт бичгийг тухай бүрт цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж байна.

Үүнд:

- Засгийн газрын тогтоол-2
- Эрүүл мэндийн сайдын тушаал-26
- УОК-ын тогтоол-3

Мэдээлэлд өөрчлөлт орох шаардлагатай үед тухай бүрт нь шинэчлэл хийгддэг.

Сургалт доорх сэдвүүдийн хүрээнд хийгдсэн.

“Үр минь тавтай морил” үйлчлүүлэгч болон тэдний ар гэрт зориулсан ээлжит цахим сургалтыг Facebook-ийн StreamYard live хэлбэрээр нийт 27 удаагийн сургалтыг 49429 хүн үзэж 612 хүн сэтгэгдэл бичсэн байна. Сургалтын сэдэв:

1. “Жирэмсний хяналтын ач холбогдол”
2. “Ковид-19 ба жирэмсэн”
3. “Эрхтэн хадгалах, хөнөөл багатай орчин үеийн эмчилгээ”, “Умайн хоргүй хавдар түлэх”, “Умайн цус алдалтыг тогтоох”
4. “Нярайн гүлгих, гэдэс дүүрэх шинж”
5. “Жирэмсэн үеийн артерийн даралт ихсэлт”



6. "Нярайн баасны онцлог"
7. "Жирэмсний хожуу хордлого гэж юу вэ", "Эх болон урагт нөлөөлөх нь"
8. Нярай хүүхдийн үс уналт, хөлрөх шалтгаан"
9. "Төрөлт гэж юу? Төрөлтөд хэрхэн бэлтгэх вэ"
10. "Нярайн шарлалт физиологийн болон эмгэг шарлалтын ялгаа авах арга хэмжээ"
11. "Төрөхийн өвдөлт намдаалт ба кесар мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг"
12. "Кесар мэс заслын тухай ойлголт"
13. "Нярай хүүхдэд илрэх дасан зохицлын өөрчлөлтүүд"
14. "Жирэмсэн үеийн бөөр үсжилт"
15. "Умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх"
16. "Нярайн уйлах шалтгаан"
17. "Хөхний эмгэгүүдийн үеийн тусламж үйлчилгээ"
18. "Жирэмсэн эмэгтэйд хийгдэх уламжлалт эмчилгээ"
19. "Түнхний үеийн дулуу хөгжил, асаргаа сувилгааны онцлог"
20. "Жирэмслэлтээс хамгаалах аргууд"
21. "Хөхөөр хооллохын ач холбогдол"
22. "Умайн хоргүй хавдар, цус алдалт"
23. "Нярайг усанд оруулах, хүйн арчилгаа"
24. "Умайн гаднах жирэмсэн"
25. "Ихэс түрүүлэлтийн үеийн тусламж үйлчилгээ"
26. "Дутуу нярайн асаргаа, сувилгаа"
27. "Бага жинтэй нярайг асрах, Имж эх саргааны ач холбогдол"

Жендерийн Үндэсний Хороо"-ноос Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилготой ОУ-ын Эмэгтэйчүүдийн Эрхийг Хамгаалах өдөр, Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ" аяныг 2022.03.01-2022.04.01-ний өдрийг хүртэл нэг сарын ӨӨРЧИЛБЕ, ХАМТДАА ҮЛГЭРЛЭЭ" аяныг амжилттай зохион байгуулсан.



“ХАЙРАА ХАЙРЛАА, ХАНДЛАГАА

<p>Зөрчлийн мэдээллийн сангийн хөтөлт</p>	<p>2022 онд Ёс зүйн хэсгийн хороонд хандсан өргөдөл 1, байгууллагын санал хүсэлтийн хайрцагаар 4 санал ирсэн. Ёс зүйн хэсгийн хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, иргэнд саналын хүрээнд авсан арга хэмжээг мэдээлсэн. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа хандлагатай холбоотой иргэдийн аман хүсэлт, саналыг хүлээн авах талаар Дотоод хяналтын ажилтантай хамтран ажиллаж байна.</p>	
<p>Дүгнэлт: Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн хэсгийн хороо нь 2022 оныг "Ёс зүйг дээдэлсэн, ээлтэй үйлчилгээг эрхэмлэх жил" болгон зарлаж 8 ажил хийхээр төлөвлөн 2022 оны эхний 11 сарын байдлаар хэрэгжилт 98%-тай байна. Эрх зүйн мэдлэг олгох, хувь хүний хөгжлийг дэмжих, ёс зүйн харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх сургалтуудыг тогтмол бүхий л чиглэлээр /тэнхим, цахим г.м/ хийж хэвшсэн.</p> <p>Эмч, үйлчлүүлэгч хоорондын ёс зүй, харицаа хандлагын талаар гомдол бүртгэгдээгүй боловч цаашид улам сайжруулах чиглэлээр хандлагын шинэлэг сургалтын арга барилыг нэвтрүүлэн ажиллана. /зөвхөн ЭМС-ын ёс зүйн тушаалаар хязгаарлагдахгүй./</p>		

ХЯНАСАН:

ЁС ЗҮЙН ХЭСГИЙН ХОРООНЫ ДАРГА  П.ДОЛГОРЖАВ

ТАЙЛАН БИЧСЭН:
НАРИЙН БИЧИГ

Б.САРАНЦЭЦЭГ

АМГАЛАН АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ
 ЁС ЗҮЙН ХЭЭСГИЙН ХОРООНЫ ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭГ

2022 оны 12 дугаар сарын 6

Улаанбаатар хот

№	Овог	Нэр	Албан тушаал	Тухайн байгууллагад ажилласан жил	Зэрэг цол	Ёс зүйн хорооны гишүүн эсэх	Ёс зүйн хороонд ажиллаж байгаа хугацаа
1.	Ламганжав	Долгоржав	Амүлаторийн тасгийн эрхлэгч	7	Зөвлөх	Тийм	3 жил
2	Баярсайхан	Одгэрэл	Хуулийн зөвлөх	2	Доктор	Тийм	2 жил
3	Ренчинтогмид	Намунсүрэн	Нярайн эмч	12	Ахлах	Тийм	3 жил
4	Бадамдорж	Саранцэцэг	Хүний нөөцийн албаны менежер	8	Ахлах	Тийм	3 жил
5	Чулууудай	Бурмаа	Сувилгахуйн албаны дарга	17	Зөвлөх	Тийм	2 жил
6	Самбуу	Мөнхтөгс	Ахлах эх баригч	8	Тэргүүлэх	Тийм	3 жил
7	Дашбаямба	Лхавгадулам	Нярайн сувилгач	10	Тэргүүлэх	Тийм	3 жил

МЭДЭЭЛЭЛ ГАРГАСАН:
 ЁС ЗҮЙН ХЭЭСГИЙН ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ



Б.САРАНЦЭЦЭГ